



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 2/94

Амардалай

Газар эзэмшүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.4 дэх заалт, сумын 2023 оны "Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэрцогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 40 дугаар тогтоолын дагуу 1 байршлын 18000 м.кв (1.8 га) газар дээр дуудлага худалдаанд оролцож ялагч болсон аж ахуйн нэгжид хавсралтаар заасны дагуу газар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал /Д.Цэнд-Аюуш/-д үүрэг болгосугай.

3. Эзэмшиж буй газраа гэрээнд заасан болзлын дагуу байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

Сумын Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 01-ны  
өдрийн А/94 дугаар тоот захирамжийн хавсралт

№	Газрын нэр	Газрын зориулалт	Талбайн хэмжээ /м2/	Дуудлага худалдаа явагдсан өдөр	Дуудлага худалдаагаар худалдагдсан үнэ	Дуудлага худалдааны ялагч	Регистрийн дугаар	Эзэмшүүлэх хугацаа /жил/
1	Шивээ овоо	3503: Цахилгаан эрчим хүчний барилга байгууламж	18000	2023.07.04	13520000	ЮПИСИ Дэлгэрцогт лэнд холдингс ХХК	3437426	15